



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.1.4, 27<sup>1</sup>.1.6, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, гамшгаас хамгаалах улсын албаны дарга, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга (хошууч генерал Г.Ариунбуян), Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга (хурандаа Т.Баярхүү) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

УХАО168

Улсын онцгой комиссын даргын  
2025 оны 7 дугаар тушаалын  
хавсралт

## ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

УХА0168

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь онцгой комиссын шуурхай штаб (цаашид “Штаб” гэх)-ын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Штаб нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед эрсдэлийн үнэлгээ хийх, нөхцөл байдлыг үнэлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, харилцан ажиллагаа, байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлагаар хангах, мэдээ, мэдээллийг нэгтгэх, дээд шатны байгууллагад хүргэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх чиг үүрэгтэй ажиллана.

1.3. Штаб нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг мөрдлөг болгон ажиллана.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Шуурхай штаб нь энэ журмын 4.1-д заасан нөхцөл байдал үүссэн үед идэвхжиж, гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалан зэрэглэлийг шат дараалан болон алгасаж шилжин ажиллана.

2.2. Энэхүү журмыг улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Штаб үйл ажиллагаандаа мөрдөнө.

2.3. Штабын бүрэлдэхүүнийг онцгой комиссын гишүүд, онцгой байдлын байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны онцгой комиссын даргын тушаалаар томилно.

2.4. Дээд шатны штабаас гарсан шийдвэр, заавар, зөвлөмж, үүргийг доод шатны штаб хэрэгжилтийг ханган ажиллана.

2.5. Онцгой комиссын шуурхай штаб байгуулах нөхцөл үүсээгүй ч нөхцөл байдлаас шалтгаалж Онцгой байдлын байгууллагын даргын тушаалаар Ажиллагааны удирдлагын газар шуурхай штаб байгуулна. Шуурхай штаб нь журмын 4.2-т заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана.

### Гурав. Удирдлага, зохион байгуулалт, бүтэц

3.1. Штаб нь үйл ажиллагаандаа тухайн шатны Онцгой комиссын хэвлэмэл хуудас, тэмдэг ашиглана.

3.2. Штаб нь дарга, орлогч, төлөвлөлт, ажиллагаа, санхүү, нөөц-хангалт, захиргаа, хэвлэл мэдээлэл, холбоо зохион байгуулалтын багуудаас бүрдэнэ. Гамшиг, ослын нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн онцлог зэргээс хамаарч багуудыг нэмж, хасаж болно.

3.3. Үүссэн нөхцөл байдлаас хамаарч зохион байгуулалт хариуцсан, мэргэжлийн чиглэл хариуцсан хоёр орлогчтой, тандалт, эрсдэлийн асуудал

хариуцсан зөвлөх, эрдэмтдийн баг, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын төлөөллийг томилж болно.

3.4. Улсын онцгой комиссын шуурхай штаб, бусад түвшний штабын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллана.

3.5. Улсын болон аймаг, нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга нь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, харилцан ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллана.

### **Дөрөв. Зэрэглэл тогтоосон нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Тухайн шатны Онцгой комисс нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, эрсдэлээс хамаарч дараах гурван зэрэглэлийг тогтооно. Үүнд

4.1.1. Ногоон

4.1.2. Шар

4.1.3. Улаан

4.2. **Ногоон зэрэглэл:** Олон хүний амь нас, эд хөрөнгө эрсдэх нөхцөл байдал үүсэж болзошгүй үе;

Ногоон зэрэглэлд нөхцөл байдлыг үнэлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, хүч хэрэгслийн судалгааг цуглуулж боловсруулах, хариу арга хэмжээг эрт төлөвлөх, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллагуудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, мэдээ, мэдээллийг нэгтгэн удирдлагыг мэдээллээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

Тус зэрэглэлд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга болон түүнтэй адилтгах албан тушаалтныг Штабт томилон ажиллуулна.

Штабын даргаар сум, дүүрэгт Онцгой байдлын хэлтсийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, аймаг, нийслэлд Онцгой байдлын газрын дарга, улсад гамшгийн төрөл нөхцөлөөс шалтгаалж Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газрын дарга нарыг тус тус томилно.

4.3. **Шар зэрэглэл:** Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон олон хүний амь нас эрсдэж, эд хөрөнгийн ихээхэн хэмжээний хохирол учирсан үе;

Энэ зэрэглэлд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг татан оролцуулах, байгууллагуудын оролцоог хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, харилцан ажиллагааг зохион байгуулах, цар хүрээг хумихад чиглэсэн арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Тус зэрэглэлд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж Штабт төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн хэлтсийн дарга, орлогч дарга болон түүнтэй адилтгах албан тушаалтныг томилон ажиллуулна.

Штабын даргаар сум, дүүрэг, аймаг, нийслэлд Засаг даргын орлогч дарга, улсад Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, дэд дарга нарыг тус тус томилно.

**4.4. Улаан зэрэглэл:** Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон хүний амь нас эрсдэж, эд хөрөнгийн ихээхэн хэмжээний хохирол учирч нэмэлтээр хүч хэрэгсэл татан оролцуулах, улсын хэмжээнд удирдлага зохицуулалтаар хангах, штабыг өргөтгөн зохион байгуулах шаардлага үүссэн үе;

Энэ үед штаб өргөтгөн зохион байгуулагдаж хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж нэмэлтээр хүн хүч хэрэгслийг татан оролцуулах, дайчилгаа зохион байгуулах, улсын хэмжээнд удирдлага зохицуулалтаар хангах, шаардлагатай газруудад хөл хорио тогтоох болон бусад захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

Тус зэрэглэлд Штабт үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн газрын дарга ба түүнээс дээш албан тушаалтныг томилон ажиллуулна.

Штабын даргаар сум, дүүрэгт Засаг дарга, аймаг, нийслэлд Засаг дарга, улсад Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд бөгөөд штабын дарга нарыг тус тус томилно.

**4.5.** Бүх шатны Онцгой комиссын дарга Штабыг бодлого, стратегийн удирдлагаар хангаж, шийдвэрлэх асуудлыг дээд шатны байгууллагад танилцуулан шуурхай шийдвэрлэнэ.

#### **Тав. Штабын даргын эрх, үүрэг**

##### **5.1. Штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

5.1.1. гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

5.1.2. салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах харилцан ажиллагааг зохион байгуулах;

5.1.3. гамшгийн голомтод шуурхай бүлгийг томилон ажиллуулах, удирдлага зохицуулалтаар хангах;

5.1.4. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мөрдөх журам, заавар, зөвлөмжийг доод шатны штаб, хуулийн этгээдэд хүргүүлэх;

5.1.5. гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албадын хүч хэрэгслийг татан оролцуулах, хуваарилах шаардлагатай хүч хэрэгслийг дайчлан ажиллуулах санал гаргах;

5.1.6. гамшгийн хариу арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх;

5.1.7. олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зохицуулахад дэмжлэг үзүүлэх;

5.1.8. нөхцөл байдалтай холбогдуулан хариу арга хэмжээнд төрийн цэргийн байгууллагыг татан оролцуулах саналыг гаргах;

5.1.9. шуурхай штабын бүрэлдэхүүн, бүрэлдэхүүнийг ажил үүргийг хуваарилж чиг үүргийг тодорхойлох;

5.1.10. штабын өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, шийдвэр гаргах;

5.1.11. шуурхай штабын бүрэлдэхүүнийг тусгай горимд шилжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг хуваарь, төлөвлөгөөг батлах, бүтцийг өөрчлөх, алба хаагчдыг штабт томилох чөлөөлөх санал гаргах;

5.1.12. иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, хууль заасан хугацаанд хариу өгөх арга хэмжээг зохион байгуулах;

5.1.13. штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт тавих;

5.1.14. үүссэн нөхцөл байдлын мэдээ, мэдээллээр дээд шатны байгууллагыг хангах, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;

### **Зургаа. Штабын орлогчийн эрх, үүрэг**

6.1. Багуудын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах;

6.2. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, шийдвэрлэх асуудлыг штабын даргад танилцуулах, мэргэжлийн талаас дэмжлэг үзүүлэх;

6.3. Багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар штабын даргыг мэдээллээр хангах;

6.4. Штабын даргыг бүх талын мэдээллээр хангах, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.5. Илүү цагийн ажлын урамшуулал, томилолтоор ажилласан үед томилолтын зардал зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх;

6.6. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

6.7. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх хүн хүч техник хэрэгслийн судалгаа гаргах, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангуулах ажлыг гүйцэтгэх;

6.8. Штабын даргын эзгүйд штабын даргын үүргийг хэрэгжүүлэх;

6.9. Бусад асуудлаар штабын даргад дэмжлэг үзүүлэх.

### **Долоо. Штабын гишүүдийн эрх, үүрэг**

#### **7.1. Штабын гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

7.1.1. гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох;

7.1.2. байгууллагынхаа чиг үүргийг хэрэгжүүлэх, төлөөлөн шийдвэр гаргах;

7.1.3. байгууллага болон удирдлага мэдээллээр хангах, харилцан ажиллагааг зохион байгуулах;

7.1.4. гамшгийн голомтод шуурхай бүлэгт томилогдон үүрэг гүйцэтгэх;

7.1.5. шуурхай штабын дотоод дүрэм, журмыг сахин биелүүлэх, цаг баримтлан ажиллах;

7.1.6. салбарынхаа хүн хүч хэрэгсэл болон бусад судалгааг гаргах;

7.1.7. иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх;

7.1.8. шуурхай штабын даргын өгсөн үүргийг цаг тухай бүр нь заасан хугацаанд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах танилцуулах;

7.1.9. ажиллах ажлын төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;

7.1.10. илүү цагийн ажлын урамшуулал, томилолтоор ажилласан үед томилолтын зардал зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх;

7.1.11. Ажлын зайлшгүй шаардлага, хүндэтгэн үзэх шалтгаан нөхцөл гарсан үед орлон гүйцэтгэх албан тушаалтныг штабын даргатай зөвшилцөн томилох;

7.1.12. бусад

### **Найм. Багуудын чиг үүрэг**

#### **8.1. Төлөвлөлтийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.1.1. гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлыг үнэлж хариу арга хэмжээг шуурхай төлөвлөх, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах;

8.1.2. төлөвлөгөөнд тусгах хүн хүч техник хэрэгслийн тооцоо судалгааг гаргах;

8.1.3. гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангуулах;

8.1.4. бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлт, дайчилгааны төлөвлөгөөг тодотгох хэрэгжилтийг хангуулах;

8.1.5. бусад

#### **8.2. Ажиллагааны баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.2.1. үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлыг үнэлэх;

8.2.2. хариу арга хэмжээг төлөвлөлтийн дагуу зохион байгуулах;

8.2.3. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх хүн хүч техник хэрэгслийн судалгааг гаргах;

8.2.4. нэрвэгдсэн хүн амын анхдагч хэрэгцээг хангахад шаардлагатай тусламж, үйлчилгээний мэдээллийг гаргах;

8.2.5. хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, дэд бүтэц, хүрээлэн буй орчинд учирсан хохирлын мэдээллийг нэгтгэх;

8.2.6. эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, штаб болон гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлаг, орон нутгийн штабын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

8.2.7. хариу арга хэмжээний чиглэлийг тодорхойлох, төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах;

8.2.8. үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээг байр зүйн болон план зураг, орон зайн мэдээллийн систем ашиглан зурагт оруулах;

8.2.9. гамшиг, аюулт үзэгдэл, ослын хариу арга хэмжээний мэдээ мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, багуудад мэдээлэх;

8.2.10. хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүн, техник, машин механизм, тоног төхөөрөмжийн тооцоог гаргах;

8.2.11. хүч хэрэгслийг гамшгийн голомтод ажиллуулах, томилгоот болон дайчилгааны хүч хэрэгслийг хуваарилах, сэлгэн ажиллуулах;

8.2.12. хариу арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах;

8.2.13. штабын бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах;

8.2.14. бусад

#### **8.3. Санхүү нөөц, хангалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.3.1. штабт шаардлагатай бичгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах, хангалтыг зохион байгуулах;

8.3.2. гамшгийн голомтод ажиллагсдын хоол, хамгаалах хувцас, хэрэгсэл, амрах байр, техник, тоног төхөөрөмж, машин механизм, шатах тослох материалын хангалтыг зохион байгуулах;

8.3.3. хариу арга хэмжээнд шаардагдах хүн хүч, техник, тоног төхөөрөмж, машин механизмын нөөцийн судалгаа гаргаж, хэрэгцээг тодорхойлох;

8.3.4. Улсын нөөцөөс гаргасан хүнс, бараа материалыг хуваарилах, тээвэрлэх хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

8.3.5. ар тал, хангалт (холбоо, тээврийн хэрэгсэл, байр, тоног төхөөрөмж, шатах тослох материал, хоол хүнс, хувцас, эмнэлгийн тусламж, санхүү)-ын талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэх, судалгаа гаргах;

8.3.6. дотоодын болон гадаад улс, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах, хүлээлгэн өгөх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

8.3.7. Бусад

#### **8.4. Захиргаа баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.4.1. Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.2. штабын үйл ажиллагааг баримтжуулах, тайлан мэдээ, судалгаа, баримт, материалыг архивлах;

8.4.3. штабын ажлын тайланг нэгтгэх, түүнд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах;

8.4.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, хариу өгөх, холбогдох багт хуваарилах;

8.4.5. лавлах болон нээлттэй утас, тусгай дугаарт ирсэн иргэдийн санал, гомдол, хүсэлт, шүүмжлэлийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх;

8.4.6. штабын үйл ажиллагааны зардал, төлбөр тооцоог гаргах;

8.4.7. штабын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ болон техник хангамж, интернэт болон тусгай сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, тэдгээрийн хэрэглэгчийн мэдээлэлд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;

8.4.8. үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний ажил, амралтын хуваарийг хийх, ажиллах нөхцөл боломжоор хангуулах;

8.4.9. ажлын цагийн хуваарийг мөрдүүлэх, ажилласан өдрийн тооцоог гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;

8.4.10. штабын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг боловсруулж, батлуулах;

8.4.11. бусад

#### **8.5. Хэвлэл, мэдээллийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.5.1. олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцан ажиллах, үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаарх мэдээллээр хангах;

8.5.2. хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах;

8.5.3. хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр гарч байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд залруулга хийх;

8.5.4. бэлтгэсэн мэдээ, мэдээллийн төслийг штабын удирдлагад танилцуулж, үүрэг, чиглэл авах;

8.5.5. бусад

#### **8.6. Холбоо зохион байгуулалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

8.6.1. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүн, штабын удирдлага хоорондын холбоог зохион байгуулах;

8.6.2. холбооны мэдээллийн техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах;

8.6.3. шаардлагатай холбоо мэдээллийн техник тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гаргах;

8.6.4. байгууллагууд хоорондын цахим сүлжээ, холбоо зохион байгуулалтыг хангах;

8.6.5. бусад

#### **Ес. Мэдээ, мэдээлэл**

9.1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Шуурхай удирдлага зарлан мэдээллийн нэгж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн удирдлага, тухайн аймгийн Онцгой байдлын газрын удирдлага нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг тухай бүр Ажиллагааны удирдлагын газрын дарга, Гал түймэртэй тэмцэх газрын дарга нарт мэдэгдэж мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

9.2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, бөгөөд штабын дарга, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга нарыг Ажиллагааны удирдлагын газрын болон Гал түймэртэй тэмцэх газрын дарга нар мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

9.3. Монгол Улсын Шадар сайдыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга нар мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

#### **Арав. Бусад**

10.1. Штабын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн шатны Онцгой комиссын дарга шийдвэрлэнэ.

10.2. Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн томилон ажиллуулсан байгууллага ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.

10.3. Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг штабын дарга тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.